

ӨМНӨХ ҮГ:



Монгол улсын Үндэсний хөгжлийн цогц бодлого, Засгийн газрын болон аймаг, сумын Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, сумын хөгжлийн төлөвлөгөөнөөс үндэс болгон боловсруулав.


Засаг даргын Тамгын газрын үйл ажиллагааны хэтийн төлөвлөгөө нь дараах зүйлийг багтаасан болно. Үүнд:

- Ойрын 3 жилд худалдан авах / нийлүүлэх бүтээгдэхүүн, ажил үйлчилгээ болон .. стратегийн зорилт
- Төсвийн жилийн хугацаанд нийлүүлэх бүтээгдэхүүний нэр төрөл, тоо хэмжээ, чанар тэдгээрийн өртөг
- Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу жилийн эцсийн санхүүгийн тайлангийн ижил үзүүлэлтээр боловсруулсан төсөв буюу төсөвлөсөн баланс
- Төсвийн шууд захирагчаас байгууллагын эд хөрөнгийг хамгаалах боловсон хүчний чадавхийг бэхжүүлэх талаар авч хэрэгжүүлэх болон өмчлөлийн эрхтэй холбогдсон бусад асуудлууд
- Төсвийн жилд гарах зардал /Санхүүгийн эх үүсвэртэй уялдсан/
- Тус байгууллагын үйл ажиллагаатай холбоотой төсөвт орох орлого зарлагын талаарх мэдээлэл

Төсвийн шууд захирагчийн мэдэгдэл, Сумын Засаг даргын Тамгын газрын дунд хугацааны хөтөлбөр болон ирэх санхүүгийн жилд нийлүүлэх хөтөлбөр арга хэмжээ төсвийн төлөвлөгөөг боловсруулахдаа Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн заалт бүрийг хэрэгжүүлэх, Тамгын газраас иргэдэд хүргэх төрийн үйлчилгээг сайжруулах, тэдний хүсэн хүлээсэн эрэлт хэрэгцээ шаардлагад тохируулан урьд жилүүдийн амжилтаа бататган тодорхой үр дүнд хүрэх асуудлыг авч төлөвлөв.


Энэхүү төлөвлөгөөний үзүүлэлтийг

ЗӨВШӨӨРЧ БАТАЛСАН:
СУМЫН ЗАСАГ ДАРГА  Б.БАЯРХҮҮ
ТӨЛӨВЛӨГӨӨ БОЛОВСРУУЛСАН:
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГА  Д.АЛТАНХУЯГ



СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ

СТРАТЕГИЙН ЗАГВАР



Гурав.Стратегийн үндсэн зорилтууд

3.1.АЛСЫН ХАРАА

Тамгын газрын албан хаагчдын мэдлэг боловсрол, мэргэжил, туршлага, мэргэшлийн ур чадвартай нэгэн зорилтод сэтгэл зүтгэлээрээ нэгдэн төлөвшсөн хамт олныг бүрдүүлж төрийн албыг тогтвортой мэргэжлийн түвшинд явуулахыг эрмэлзэнэ.

3.2.ЭРХЭМ ЗОРИЛГО, ЭРХЭМЛЭХ ҮНДСЭН ЗАРЧИМ:

Сумын Засаг даргын Тамгын газар нь Засаг даргыг цаг үеэ олсон зөвлөгөө дэмжлэг, бүх талын мэдээллээр тасралтгүй хангаж иргэдэд төрөөс үзүүлэх үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулан сум эдийн засаг, нийгмийн хувьд бие даан хөгжих үндсэн суурийг тавих явдал мөн.

Хууль эрх зүй, төрийн захиргааны өндөр мэдлэгтэй төрийн албан хаагчдаар Тамгын газрын хамт олныг бүрдүүлж үүрэг хариуцлагаа бүрэн ухамсарлан ажиллах.

Төрийн албаны хууль болон бусад хууль тогтоомжийг чанд сахин өргөсөн тангарагтаа чин үнэнч, шударгаа аливаа үзэл суртлаас ангид байх зарчмыг баримтлаж ажиллах.

Иргэдэд үйлчлэх үйлчилгээндээ хөнгөн шуурхай, соёлтой байдлыг нэвтрүүлэн үнэн бодитой, алдаа мадаггүй, цаг үеэ олсон мэдээлэл үйлчилгээг үзүүлэх.

3.3.ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭ:

ДОТООД ОРЧИН		
ЧИГЛЭЛ	ДАВУУ ТАЛ	СУЛ ТАЛ
Удирдлага зохион байгуулалт	-Төсвийн тухай хуулиар хэрэгжиж буй үр дүнд чиглэсэн хөтөлбөр арга хэмжээг нийлүүлэх чадварлаг боловсон хүчнээр боломжийн хэмжээнд хангагдсан. -Тамгын газрын ажиллагсад олон жилийн судалгаанд тулгуурлан ирээдүйгээ харсан үйл ажиллагаа явуулдаг. -Иргэдийн эрэлт хүсэлтийг хүлээн авч дүгнэлт хийх чадвартай, -Ажилтнуудын ажиллах өрөө тасалгаа, зарим техник хэрэгслээр хангагдаж байгаа. -Ажлын нарийн тодорхойлолттой үйл	-Төсвийн тухай хуулийн талаар бүрэн гүйцэт мэдлэгтэй болж чадаагүй. - Төрийн хууль тогтоомж гаргасан шийдвэр, зохиож байгаа жил хүн бүрт хүрдэггүй, биелэлтийг хянах дүгнэх явдал хангалтгүй. - Ажлаа нийтэд мэдээлэх сурталчлах ажил хангалтгүй, - Ажилтнуудын ажил гүйцэтгэх чадвар бүтээлч санаачлага жигд биш - Тамгын газрын ажилтан бүр компьютер техник хэрэгслээр бүрэн хангагдаагүй, техник хэрэгсэл дээр ажиллах чадвар дутагдалтай.

	ажиллагааны төлөвлөгөө боловсруулан мөрдөж биелэлтэнд нь байнгын хяналт тавьдаг.	
Эдийн засаг, санхүүгийн нөхцөл байдал	<ul style="list-style-type: none"> - Төсвийн байгууллагууд батлагдсан төсвийнхөө хүрээнд боломжийн үйл ажиллагаа явуулж хэвшиж байгаа. - Нутаг дэвсгэрийн байдал дэд бүтцийн хувьд өндөр хүчдэлийн төвийн шугамд холбогдсон улсын нийслэл, аймгийн төв холбогдсон заммал замдаа харьцангуй ойр боломжтой орчинд оршдог/ - Өр авлага хуримтлагдаагүй. 	<ul style="list-style-type: none"> - Байгаль цаг уурын эрс тэс орчинд МАА-н үйлдвэрлэлийн үйл ажиллагаа эрхэлдэг. - Үе үе ган зуд болдогоос эрсдэлд орох магадлал өндөртэй. - Ажил үүргээ явуулах санхүүгийн нөөц хангалтгүй. - Орлого нэмэгдүүлэх шинэ эх үүсвэр муутай жижиг дунд үйлдвэрлэл үйлчилгээ сул хөгжсөн.
ГАДААД ОРЧИН		
ЧИГЛЭЛ	ДАВУУ ТАЛ	СУЛ ТАЛ
Улс төрийн хүчин зүйл	Улс төр нийгэм эдийн засгийн тогтвортой байдал бий болсон.	<ul style="list-style-type: none"> - Зарим тохиолдолд улс төржих хандлага гарч болзошгүй.
Нийгмийн салбарын хэмжээнд	<ul style="list-style-type: none"> - ЕБС-ийн сургалтын орчин бүрдэж мэргэжлийн багш нараар бүрэн хангагдаж үйл ажиллагаа нь жигдэрсэн. - Эрүүл мэндийн төвийн үйл ажиллагаа тогтворжсон боловсон хүчнээр 90% хангагдсан, түргэн тулсамжийн машинтай техник хэрэгслэлээр бүрэн хангагдсан. - Соёл урлагийн үйлчилгээ явуулах зориулалтын барилга байгууламжтай барилгад их засвар хийгдсэн, номын сан, ном хэвлэлийн хүрэлцээ хангамж сайжирсан. - Сургуулийн өмнөх боловсролын үйл ажиллагаа хэвийн мэргэжлийн багш нараар хангагдсан сургалтын 	<ul style="list-style-type: none"> - Хамран сургалт багатай интернет, камержуулалт байхгүй мэргэжлийн багш нарыг бодлогоор бэлтгэдэггүйгээс тогтвор суурьшил муутай. - Өрөө тасалгааны багтаамж хүрэлцээ муу бохир, цэврийн шугамыг ашиглаж чаддаггүй, багийн эмч нар унаагүй, эмийн эргэлтийн сангийн хүрэлцээ муу - Техник тоног төхөөрөмж хөгжмийн зэмсэг дутагдалтай, орон нутаг судлах танхимгүй, хөдөөгийн багуудад соёлын үйлчилгээ явуулах машин унаа, цахилгааны эх үүсвэр байхгүй. - Суурин хүн ам цөөн учир бүлгийн хүүхэд цөөн цэвэр бохир усны хангамж сул, байрны хүрэлцээ дутмаг, орчин үеийн хэрэгцээ

	орчин бүрдсэн.	шаардлагын нөхцөл бага.
Байгаль орчны хүрээнд	Бэлчээрийн усан хангамж сайн, газар тариалангийн талбай хангалттай, тал хээр, говь хосолсон бэлчээртэй, бэлчээрийн менежмент хийх боломжтой.	- Бэлчээрийн даац хэтрэх төлөвтэй ургамлын бүрхэвч алдагдаж элсний нүүдэлд өртөмтгий болж байгаа, хортон мэрэгчийн тархалт ихэссэн.

3.4. СТРАТЕГИЙН ЗОРИЛТ /ХҮРЭХ ҮР ДҮН /

Сумын Засаг даргын Тамгын газар нь Эрхэм зорилгынхоо хүрээнд дор дурьдсан үйл ажиллагааны стратегийн зорилтуудыг хэрэгжүүлнэ. Үүнд:
Стратегийн зорилт 1.
Нутгийн өөрөө удирдах байгууллага, нутгийн захиргааны байгууллагын ажлын уялдааг сайжруулан, орон нутагт хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг шуурхай зохицуулалтаар ханган, иргэдэд хүргэх төрийн үйлчилгээний чанар хүртээмжийг дээшлүүлэх.
Стратегийн зорилт 2:
Сумын хөгжлийг хангах үйл ажиллагааг зохицуулалт зохион байгуулалтаар Аймаг, сумын Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг шуурхай зохицуулалтаар хангах.
Стратегийн зорилт 3.
Засаг даргын Тамгын газрыг хөгжүүлж, иргэдэд мэргэшсэн тогтвортой, чадварлаг төрийн албаар үйлчлэх бүтэц тогтолцоог бүрдүүлэх.
Стратегийн зорилт 4.
Нутаг дэвсгэртээ эдийн засаг, байгаль орчин, нийгмийн хөгжлийг хангах үйл ажиллагааг зохицуулалт, зохион байгуулалтаар хангах.

3.5. ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХАМРАХ ХҮРЭЭ:

Сумын Засаг даргын Тамгын газрын үйл ажиллагааны хамрах хүрээг дор дурьдсанаар сонгож байна.

3.6.ЭН ТЭРГҮҮНД ХУДАЛДАН АВАХ /НИЙЛҮҮЛЭХ ХӨТӨЛБӨР/

Засаг даргын Тамгын газрын стратегийн зорилтыг хангахын тулд зайлшгүй нийлүүлэх бүтээгдэхүүний ангийг дор дурьдсанаар тодорхойлж байна.

Үйл ажиллагааг зохицуулалт, зохион байгуулалтаар хангах.

3.7.СТРАТЕГИЙН ЗОРИЛТ, ХӨТӨЛБӨР ХООРОНДЫН УЯЛДАА

<p>Стратегийн зорилт 1. Орон нутагт хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг шуурхай зохицуулалтаар хангаж, иргэдэд хүргэх төрийн үйлчилгээний чанар хүртээмжийг дээшлүүлэх.</p>	<p>Хөтөлбөр 1 Хөтөлбөр 2 Хөтөлбөр 3 Хөтөлбөр 4 Хөтөлбөр 5 Хөтөлбөр 6 Хөтөлбөр 7 Хөтөлбөр 8</p>
<p>Стратегийн зорилт 2. Аймаг, сумын Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг шуурхай зохицуулалтаар хангах.</p>	<p>Хөтөлбөр 4 Хөтөлбөр 1 Хөтөлбөр 2</p>
<p>Стратегийн зорилт 3. Засаг даргын Тамгын газрыг хөгжүүлэх, иргэдэд мэргэшсэн тогтвортой, чадварлаг төрийн албаар үйлчлэх, бүтэц тогтолцоог бүрдүүлж үйлчилгээний чанарыг сайжруулах.</p>	<p>Хөтөлбөр 9 Хөтөлбөр 10 Хөтөлбөр 11 Хөтөлбөр 5 Хөтөлбөр 6</p>
<p>Стратегийн зорилт 4 Нутаг дэвсгэртээ Эдийн засаг байгаль орчин, нийгмийн хөгжлийг хангах үйл ажиллагааг зохицуулалт, зохион байгуулалтаар хангах.</p>	<p>Хөтөлбөр 13 Хөтөлбөр 14 Хөтөлбөр 15 Хөтөлбөр 16 Хөтөлбөр 17 Хөтөлбөр 18 Хөтөлбөр 19 Хөтөлбөр 20 Хөтөлбөр 21</p>

ДӨРӨВ.ТӨСВИЙН ЖИЛД НИЙЛҮҮЛЭХ БҮТЭЭГДЭХҮҮН

4.1.Хөтөлбөр 1. Засаг даргад үзүүлэх үйлчилгээ

Энэ хөтөлбөрийн хүрээнд:

1.1.Засаг даргын бодлогын бичиг баримт боловсруулах.

1.2.Засаг даргад үзүүлэх захиргааны үйлчилгээ

Шалгуур үзүүлэлт:

№	Ажил үйлчилгээ	Тоо хэмжээ	Цаг хугацаа	Чанар үр дүн	Өртөг
1.	Сумын Засаг даргаас аймгийн засаг даргатай байгуулах үр дүнгийн гэрээний төсөл бэлтгэх.	1	Жил бүр	1.Сумаас аймгийн Засаг даргад нийлүүлэх хөтөлбөрийг бүрэн тодорхойлж чадсан байна. 2.Төсвийн тухай хуулийн заалтыг баримталсан	

				хугацаа алдаагүй байна.	
2.	Төсвийн байгууллагын шууд захирагчтай байгуулах үр дүнгийн гэрээний төсөл бэлтгэх дүгнэх.	6	Жил бүр	1.Засгийн газар аймаг, сумын Засаг даргын мөрийн хөтөлбөртэй уялдуулан нийлүүлэх хөтөлбөр, түүний шалгуур үзүүлэлт хүлээх хариуцлага тодорхой болсон байна. 2.Гэрээг хуулийн хугацаанд байгуулсан байна. 3.Гэрээг хагас бүтэн жилээр дүгнэж баталгаажуулсан байна.	
3.	Орон нутгийн төсөв зохиох	1	Жил бүр	1.Төсвийн тухай хуулийн дагуу боловсруулагдсан байна. 2.Төсвийг сумын нөөц боломжийг бүрэн дайчлахаар нарийн тооцоо судалгаа, норм нормативыг үндэслэн хугацаанд нь боловсруулсан байна.	
4.	Үндсэн чиглэл боловсруулах	1	Жил бүр	Сумын нийгэм эдийн засгийн зорилтыг хангах түвшинд хөрөнгө хүн хүчний нөөцөд тулгуурлан боловсруулсан байх. Байгууллага иргэдийн саналыг өргөн тусгасан байна. 3.Сумын ИТХ-аар хэлэлцэгдэж баталгаажсан байна.	
5.	Засаг дарга, Тамгын газрын жилийн ажлын тайланг бичиж төсвийн тайланг гаргах.	1	Жил бүр	1.Тайлангийн жилд зохиосон ажлаа үнэн зөв бүрэн тусгасан байна. 2.Төсвийн тайланг анхан шатны болон ня-бо бүртгэлийн үнэн бодит тоо мэдээнд тулгуурлан хугацаанд нь гаргасан байна. 3.Аудитын дүгнэлт хийлгэж баталгаажуулсан байна.	
6.	Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн биелэлтийг гаргах	1	Жил бүр	1.Хөтөлбөрийн үзүүлэлтийг хариуцсан ажилтан бүртэй биелэлтийн тооцоо хийнэ.	

				<p>2. Үзүүлэлт бүрийн хэрэгжилтийг тодорхой хүрсэн үр дүнгээр тооцон гаргана.</p> <p>3. Дүнг ИТХ-аар нийтэд мэдээлсэн байна.</p>
7.	Засаг даргын зөвлөл, ИТХ, Тэргүүлэгчдийн хуралдааны бэлтгэл хангах зохион байгуулах.	12	Сар бүр	<p>1. Хэлэлцэх асуудлыг холбогдох ажилтнуудаар бэлдүүлэх.</p> <p>2. Хуралдаанд оролцох хүмүүсийг зарлан бэлэн байлгах</p> <p>3. Хурал зөвлөгөөнөөс гарах шийдвэрийн төслүүдийг хууль зүйд нийцүүлэн чанартай бэлдсэн байх.</p>
8.	Иргэдийн өргөдөл гомдол санал хүлээн авч шийдвэрлэх.	Ирсэн тоогоор	Тухай бүр	<p>1. Санал, өргөдөл гомдол, хүсэлтийг хүлээн авч барагдуулах хуулийн заалтыг хангасан байна.</p> <p>2. Иргэдээс санал хүсэлт, өргөдөл гомдлоо чөлөөтэй гаргах нөхцлийг хангаж хайрцаг, дэвтэр, цахим хаяг ажиллуулсан байна.</p> <p>3. Санал, өргөдөл, гомдол, хүсэлтийг хугацаанд нь шийдвэрлэн хариу өгч мэдээг хагас бүтэн жилээр гаргасан байна.</p>
9.	Засаг даргын захирамж, албан даалгавар, хэлэх үг илтгэлийн төсөл бэлтгэх.	Гарсан тоогоор	Тухай бүр нь	<p>1. Төрийн албан хэрэг хөтлөлтийг заавар стандартын дагуу хөтлөж боловсруулсан байна.</p> <p>2. Захирамж шийдвэрийг хууль эрх зүйд нийцүүлэн эрхийг зөрчилгүй боловсруулсан байна.</p> <p>3. Боловсруулан гаргасан бичиг баримтын төсөл нотолгоо дүгнэлттэй утга найруулга сайтай бичигдсэн байна.</p>

Хөтөлбөр 2. Мэргэжил арга зүйн удирдлагаар хангах:

Хөтөлбөрийн хүрээнд:

2.1. Багийн Засаг даргад мэдээлэл өгөх, арга зүйгээр хангах.

2.2. Суманд ажиллаж байгаа аж ахуйн нэгж, албан байгууллага болон иргэдэд тогтоол шийдвэр, заавар журам хүргүүлэх, зааварчилгаа өгөх, хууль дүрэм сурталчлах.

Шалгуур үзүүлэлт:

№	Ажил үйлчилгээ	Тоо хэмжээ	Цаг хугацаа	Чанар үр дүн	Өртөг
1.	Багийн засаг дарга нарыг сар бүр цуглуулан мэдээлэл өгч ажиллах	12	Сар бүрийн 25	1.Засаг дарга, ИТХ-ын тэргүүлэгчдийн дарга, ЗДТГ-ын түшмэд, албатуудыг оролцуулан тодорхой мэдээллээр хангаж үүрэг даалгавар өгсөн байна.	
2.	Багт сард зохиох ажлын жагсаалт өгч биелэлтийг тооцож байх.	12	Сар бүр	1.Сард зохион байгуулах ажил нь тодорхой болсон байна. 2.Ажлын биелэлтийг сар бүр гарган ирүүлж зохиосон ажлаа дүгнүүлэн цалингаа авдаг болно.	
3.	Байгууллагын дарга эрхлэгч нарыг сар бүр цуглуулж үүрэг даалгавар өгч ажилтай нь танилцан мэдээлэл өгөх.	12-оос доошгүй	Сар бүр	1.Сум байгууллагын өмнө тулгарч байгаа асуудлыг цаг алдалгүй хамтын санаа бодлоор шийдвэрлэх аргыг олсон байна. 2.Тодорхой үүрэг даалгавартай ажиллаж үр дүнд хүрсэн байна. 3.Тухайн байгууллагын талаар удирдлага тодорхой мэдээлэлтэй болсон байна.	4.
4.	Байгууллагын дарга эрхлэгч нараас сарын хөтөлбөрийн нийлүүлэлтийн тайланг авч дүгнэлт хийх.	12	Сар бүрийн 30-ны дотор	1.Сард нийлүүлсэн хөтөлбөр тодорхой болж санхүүжилт авах үндэс болсон байна. 2.Мэдээ тайлан үнэн зөв хугацаандаа гарч аймагт явуулах хөтөлбөрийн жагсаалт гаргах үндэс болсон байна.	
5.	Байгууллагуудын дарга нарыг эрхлэх ажлын чиглэлтэй холбоотой шийдвэр заавар удирдамжаар хангаж ажиллах.	Гарсан тоогоор	Тухай бүр нь	1.Дээрээс ирсэн бүх заавар удирдамж, шийдвэр, ЗДТГ-ын бичиг хэргээр дамжин Засаг даргаар заалт гаргуулж цаг алдалгүй зохих байгууллагад очсон байна. 2.Байгууллагын дарга нарт сумын Засаг даргаас тодорхой удирдлага заавар өгч	

				ажил нь хэвийн чанартай явагдах нөхцөл бүрдсэн байна.	
6.	Байгууллага иргэдэд хууль дүрэм сурталчлах ажлыг тусгай графикаар явуулна.	Эрхийн актын тоогоор	Тухай бүр	1.Нийтээр мэдвэл зохих гол гол хуулиар иргэд тодорхой ойлгоцтой болсон байна. 2.Байгууллага иргэдийн дунд хууль тогтоомж сурталчлах тайланлан ойлгуулах талаар зохиох ажил тогтмолжсон байна. 3.Зохиосон ажлаа албан ёсоор баталгаажуулж тэднээс санал дүгнэлт авсан байна.	
7.	Суманд ажиллаж байгаа аж ахуйн нэгж байгууллага иргэдэд заавар журмаар хангаж тусгай зөвшөөрөл олгох ажил үйлчилгээг дэмжих.	Тухай бүр	Байнга	1.Согтууруулах ундаа борлуулах нөхцөл хангасан нэгж иргэдэд зөвшөөрөл олгосон байна. 2.ШТС-уудад галын аюулгүй байдал хангагдсан байна. 3.үйлчлүүлэгчдийн эрх ашигт нийцсэн аюулгүй байдлыг бүрэн хангасан цэг салбарт үйлчилгээ хийх тусгай зөвшөөрөл олгогдсон байна.	

Хөтөлбөр 3.Хяналт шалгалт хийх:

Хөтөлбөрийн хүрээнд: Хууль тогтоомж, эрх зүйн бусад акт, хөтөлбөр, төсөл зэрэг эрх бүхий байгууллагын шийдвэрийн биелэлтийг шалгах, үйлчилгээний чанар, үр дүн, үр нөлөө ямар байгааг судлан тогтоох, дутагдлыг арилгуулах зэрэг ажил үйлчилгээ орно.

№	Ажил үйлчилгээ	Тоо хэмжээ	Цаг хугацаа	Чанар үр дүн	Өртөг
1.	Хууль тогтоомж, эрх зүйн бусад актын биелэлтийг шалгах.	12	Заасан хугацаанд	1.Тусгай удирдамжийн дагуу шалгасан байна. 2.Хууль тогтоомж эрх зүйн актын биелэлт ямар байгааг, ямар заалт журам зөрчигдөж байгаад нэгдсэн дүгнэлт хийсэн байна. 3.Шалгалтын баримт ёсоор үйлдэгдсэн байна.	
2.	Худалдаа эрхлэгч цэг салбар	2	Хагас, бүтэн	1.хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалах хууль	

	иргэдийн хүнсний аюулгүй байдалд үзлэг хийх.		жилээр	тогтоомжийн заалт мөрдөгдсөн байна. 2.Чанар стандартын шаардлага хангасан бүтээгдэхүүнээр үйлчилдэг болсон байна.
3.	Аж ахуйн нэгж, байгууллага, айл өрхийн байгаль орчныг бохирдуулахад нөлөөлж байгаа болон хамгаалах талаар хийж байгаа ажлыг шалгах.	2	Хагас бүтэн жилд	1.Хог хаягдлаа хэрхэн зайлуулж байгааг шалган тогтоосон байна. 2.Илэрсэн зөрчилд арга хэмжээ авагдсан байна. 3.Айл өрх, албан газрууд бие засах газар, бохир усны цооногтой болсон байна.

Хөтөлбөр 4.төрийн үйлчилгээг иргэдэд чирэгдэлгүй чанартай хүргэх.

Хөтөлбөрийн хүрээнд:

4.1.Төрийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх

4.2.Төрийн албан хаагчдын ажлын байр, ажиллах нөхцлийг сайжруулах.

4.3.Төрийн албан хаагчдын ажиллах, амьдрах нөхцөл бололцоог нэмэгдүүлэх.

№	Ажил үйлчилгээ	Тоо хэмжээ	Цаг хугацаа	Чанар үр дүн	Өртөг
1.	Эрх зүйн танхимтай болж иргэдэд цахим мэдээлэл авах боломж бүрдүүлэх.	1	2014-2015 он	Иргэд шаардлагатай хууль эрх зүйн мэдээллээ шуурхай авдаг болсон байна.	
2.	Багуудын төвийг засварлан тохижуулж багийн Засаг дарга нарыг унаажуулах.	4	2014-2015 он	Төрийн үйлчилгээг иргэдэд хүргэх нөхцөл сайжирсан байна.	
3.	Засаг даргын Тамгын газрыг дотоод сүлжээнд бүрэн хамруулж компьютер техник хэрэгслээр хангах.	15	2014-2015 он	ЗДТГ-ын ажилтнууд техник хэрэгслээ бүрэн шинэчилсэн дотоод сүлжээнд холбогдож үйлчилгээ хурдан шуурхай болсон байна.	
4.	Иргэдэд төрийн үйлчилгээг шуурхай хүргэх нэг цэгийн үйлчилгээний төвийг техник хэрэгслээр хангах.	1	2014 он	Иргэдэд төрийн үйлчилгээг чирэгдэлгүй ханган шуурхай хүргэх боломж бүрдсэн байна.	
5.	Төрийн албыг шаардлага хангасан мэргэжилтнээр	1	2014-2015 он	Иргэдэд мэргэшсэн тогтвортой чадварлаг төрийн албаар үйлчлэх бүтэц тогтолцоо бүрдсэн	

хангахын тулд хүний нөөцийн бодлого барьж "Боловсон хүчин" хөтөлбөр боловсруулж тэдний нийгмийн баталгааг хангах.			байна.	
---	--	--	--------	--

Хөтөлбөр: 5.Иргэдэд иргэний бүртгэл мэдээллийн үйлчилгээ үзүүлэх.

Хөтөлбөрийн хүрээнд:

5.1.Иргэний гэр бүлийн байдлыг бүртгэх.

5.2.Иргэний үнэмлэхжүүлэх

5.3.Шилжин суурьших хөдөлгөөнийг бүртгэх

5.4.Нотариатын үйлчилгээ үзүүлэх.

№	Ажил үйлчилгээ	Тоо хэмжээ	Цаг хугацаа	Чанар үр дүн	Өртөг
1.	Иргэний гэр бүлийн байдлын 8 төрлийн бүртгэл хийх, нэмэлт өөрчлөлт оруулах	Үйлчилгээний тоогоор	Тухай бүр нь	1.Иргэний бүртгэлийн тухай хууль, Захиргааны хариуцлагын тухай хууль зэрэг хуулийн заалтанд нийцсэн байна.	
2.	Иргэний үнэмлэх аваагүй байгаа иргэдэд материал бүрдүүлж үнэмлэх олгох буюу шинээр 16 нас хүрсэн залуусаар андгай өргүүлэх.	16 настай хүний тоогоор	Материал хүлээн авснаас хойш, 30 хоногийн дотор	1.Иргэний бүртгэлийн тухай хууль, Гэр бүлийн тухай хууль, Захиргааны хариуцлагын тухай хууль зэрэг заалтанд нийцсэн байна.Хуулийн дагуу хийгдсэн байна. 2.Иргэний үнэмлэхэд бичигдэх мэдээллийг үнэн зөв алдаагүй хийж гүйцэтгэсэн байна. 3.Иргэний үнэмлэхийг "Иргэний бүртгэлийн тухай хууль"-д заасны дагуу холбогдох бичиг баримтыг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор олгосон байна.	
3.	Иргэнийг аймаг дотроо шилжихэд ХААТР- бичиг бүртгэх, өөр аймаг хотод шилжихэд тодорхойлолт		Тухай бүр нь	1.Иргэний бүртгэлийн тухай хуульд заасны дагуу хийж гүйцэтгэнэ. 2.Иргэний Засаг захиргаа завсардалт байхгүй болсон байна.	

	хийж бүртгэх.				
4.	Нотариатын суманд зөвшөөрөгдсөн бүх үйлчилгээг хийх.	Үйлчил-Гээний тоогоор	Тухай бүрт нь	1.Нотариатын тухай хуулийн заалтын дагуу гүйцэтгэнэ. 2.Иргэдээс ямар нэгэн гомдол гараагүй байна. 3.тэмдэгтийн хураамжийн төлөвлөгөөг биелүүлсэн байна.	

Хөтөлбөр 6.Цэрэг, Батлан хамгаалах,Онцгой комиссын үйл ажиллагааг зохион байгуулах.

Хөтөлбөрийн хүрээнд:

6.1.Цэргийн алба хаалгах.

6.2.Дайчилгааны төлөвлөгөөг хангах.

6.3.Гамшигтай тэмцэх ажлын бэлэн байдлыг хангах зэрэг үйл ажиллагаа хамаарна.

№	Ажил үйлчилгээ	Тоо хэмжээ	Цаг хугацаа	Чанар үр дүн	Өртөг
1.	Цэргийн тоо бүртгэл хөтлөх.	Заасан насны эрчүүдийн тоогоор	Заасан хугацаанд	1.18-25 насны эрчүүд тусгай мэргэжлийн эмэгтэйчүүдийг бүртгэлд бүрэн хамруулах.	
2.	Цэргийн алба хаалгах.	Цэргийн штабаас тогтоосон лимтийг хангах.	Заасан хугацаанд	1.18-25 насны эрчүүдийг цэрэг татлагын комиссоор оруулж хяналтын тоог хангах. 2.Гэрээт болон дүйцүүлэх албанд элсэх эрчүүдийн материалыг бүрэн бүрдүүлж өгөх.	
3.	Дайчилгааны төлөвлөгөөнд тодотгол хийж даалгаварыг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах.	Хөдөлгөөн гарсан тухай бүр	Тухайн үед	1.Дайчилгааны төлөвлөгөө нь дайчилгааны тухай Монгол улсын хуульд заасан шаардлагыг хангаж байх. 2.Төлөвлөгөөний тодотголыг бүрэн хийж бэлэн байдлыг хангуулсан байх.	
4.	Онцгой комисс, Гамшгаас хамгаалах бэлэн байдлыг хангуулах.	Команд штабын гишүүдийн тоогоор	Тухайн үед	1.Гамшгаас хамгаалах шуурхай командыг орон тооны хүн хүч, техник хэрэгслэлээр томилгоожуулж болзошгүй гамшиг осолтой тэмцэхэд бэлэн байлгах.	

				<p>2.Сумын Гамшгаас хамгаалах төлөвлөгөөг болзошгүй цагийн байдалтай нягт уялдуулан бодитой хийж баталгаажуулсан байх ба тодотгосон байна.</p> <p>3.гамшиг ослоос иргэд хөрөнгийг аврах, хамгаалах мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч сургасан байна.</p>
--	--	--	--	--

Хөтөлбөр 7.Татварын үйлчилгээ

Хөтөлбөрийн хүрээнд:

7.1.Татварын орлого бүрдүүлэх

7.2.Татварын хяналт шалгалт хийх, тайлагнах.

7.3.Татварын мэдээлэл сурталчилгаа хийх зэрэг ажил үйлчилгээ

№	Ажил үйлчилгээ	Тоо хэмжээ	Цаг хугацаа	Чанар үр дүн	Өртөг
1.	Татвар ноогдуулж цуглуулах үйл ажиллагааг зохион байгуулах.	Татвар төлөгчдийн тоогоор	Байнга	<p>1.Татварын орлогын төлөвлөгөөг нэр төрлөөр нь улирал бүр 100-аас дээш хувиар биелүүлэх.</p> <p>2.Татварын хуулийн заалт бүрэн хэрэгжсэн байна.</p> <p>3.татварын урьд оны өрийг 90-ээс доошгүй хувиар барагдуулсан байх ба шинээр өр үүсгэхгүй байна.</p>	
2.	Татварын хяналт шалгалт хийх	Иргэн 10 ААН-2	4,12 сард	<p>1.Татварын зөрчил буурсан байна.</p> <p>2.Илэрсэн зөрчлийг бүрэн арилгасан байна.</p>	
3.	Татварын мэдээлэл сурталчилгаа хийнэ	4 багт	4,12 сард	<p>1.Татварын хуулийг суманд хамааралтай заалтыг иргэдийн 60-аас доошгүй хувь нь мэддэг болсон байна.</p> <p>2.Татварын хуулиар булан самбар хийж аялуулах гарын авлага материалаар холбогдох хүмүүсийг хангасан байна.</p>	

Хөтөлбөр.8.Нийгмийн халамж, хөдөлмөр зохицуулалтын үйлчилгээ:

Хөтөлбөрийн хүрээнд:

8.1.Тэтгэвэр тэтгэмж олгох.

8.2.ядуурлыг бууруулах, өрхийн амьжиргааны чадавхийг дээшлүүлэх.

8.3.хөдөлмөр эрхлэлтийг зохицуулах зэрэг ажил үйлчилгээг хамаарна.

№	Ажил үйлчилгээ	Тоо хэмжээ	Цаг хугацаа	Чанар үр дүн	Өртөг
1.	Нийгмийн халамж хамгаалал шаардлагатай иргэдэд халамж үйлчилгээг хөрөнгийн зохих нөөцөд тулгуурлан үзүүлэх.	Халамж үйлчилгээний тоогоор	Жилдээ	1.Нийгмийн халамжийн хуулийн заалтыг хэрэгжүүлж ажиллах. 2.Ахмад настан болон хөгжлийн бэрхшээлтэй иргэн түүнд үзүүлэх хөнгөлөлтийн талаар хуулийн заалтыг хэрэгжүүлж ажиллана.	
2.	Өрхийн амьжиргааг дэмжих тогтвортой амьжиргаа төслийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах.	Шалгарсан төслийн тоогоор	Сар бүр	1.Бүх өрхийн орлогыг шинэчлэн тодорхойлсон байна. 2.Амьдрах ухааны болон мэргэжлийн баримжаа олгох сургалтууд зохион байгуулан төсөл шалгаруулж зээл олгоно.	
3.	Хөдөлмөр эрхлэлтийг зохицуулах, ажлын түр болон байнгын байр нэмэгдүүлэх, ажилгүйдлийг бууруулах зэрэг арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.	10-аас доошгүй	Жилдээ	1.хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хуулийн заалтыг хэрэгжүүлж ажиллана. 2.Сумын хүн амын хөдөлмөр эрхлэлтийн судалгааг нарийвчлан гаргаж ажил эрхлээгүй нөөцийг бүртгэх. 3.Жижиг үйлдвэр үйлчилгээний цэг салбарыг дэмжиж ажлын байр 10-аас доошгүйг бий болгож ажилгүйдлийг 20 хувиар бууруулах.	

Хөтөлбөр 9.Эрүүл мэндийн болон нийгмийн даатгалын сангийн үйлчилгээ үзүүлэх.

Хөтөлбөрийн хүрээнд:

9.1.Нийгмийн даатгалын сан бүрдүүлэх.

9.2.Эрүүл мэндийн даатгалын сан бүрдүүлэх.

9.3.Тэтгэвэр тэтгэмж бодож олгох зэрэг ажил үйлчилгээг хамаарна.

№	Ажил үйлчилгээ	Тоо хэмжээ	Цаг хугацаа	Чанар үр дүн	Өртөг
1.	Нийгмийн даатгалын санг бүрдүүлэх.		Сар улирлаар	1.Нийгмийн даатгалын хуулийн холбогдох заалтыг бүрэн биелүүлсэн байна. 2.Нийгмийн даатгалын сангуудын орлогын төлөвлөгөөг сар бүр жигд ханган биелүүлсэн байна.	

				3.Тэтгэврийн нэрийн данс нээлгэвэл зохих бүх хүний 90-ээс доошгүй хувийг хамруулах. 4.Нийгмийн даатгалын сайн дурын даатгалд хамрагдагсдыг урьд оноос нэмэгдүүлэх.	
2.	Эрүүл мэндийн даатгалын сан бүрдүүлэх.		Жилдээ	1.Эрүүл мэндийн даатгалын хуулийн заалтыг бүрэн биелүүлсэн байна. 2.Эрүүл мэндийн даатгалын сангийн орлогын төлөвлөгөөг биелүүлсэн байна. 3.ЭМД-ын сан бүрдүүлэх сарын бүтээлч ажил зохион орлогыг 65 хувиар биелүүлсэн байна.	
3.	Тэтгэвэр тэтгэмж бодож олгох үйлчилгээ үзүүлэх.	Тогтоол Госон тоогоор	Тухай бүрт нь	1.Тухайн онд тэтгэврийн нас хүрсэн материалаа бүрдүүлсэн бүх хүний тэтгэвэрийг бодно. 2.Тэтгэвэр тэтгэмжийг сар бүр тавьсан байна.	

Хөтөлбөр 10.Нийгмийн хэв журмын зохицуулалт үйлчилгээ

Хөтөлбөрийн хүрээнд:

10.1.Нийгмийн хэв журам сахиулах

10.2.Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үйлчилгээ зэрэг ажил үйлчилгээг хамаарна.

№	Ажил үйлчилгээ	Тоо хэмжээ	Цаг хугацаа	Чанар үр дүн	Өртөг
1.	Гэмт хэрэг, захиргааны зөрчил гарахаас урьдчилан сэргийлэх, ажлын хариуцлага, сахилга дээшлүүлэх ажлыг зохион байгуулах.	4	Жилдээ	1.гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх хөтөлбөрүүдийн хэрэгжилтийн байдал тодорхой болсон байна. 2.Архидан согтуурах зуршил эрс багасч архигүй орчин, хамт олон бүрдүүлэх хөдөлгөөн өрнөсөн байна. 3.ЗДТг-ын ажилтны ажлын хариуцлага, сахилгын талаар иргэдийн үнэлгээ дээшилсэн байна. 4.Иргэдийн дунд хууль ёсыг дээдлэн сахиx	2.

				хандлага дээшилсэн, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд олон нийтийн оролцоог чиглүүлсэн байна.
2.	Зонхилон гарч байгаа гэмт хэрэг зөрчлийн шалтгаан нөхцлийг тогтоон арилгах.	4	Улирал бүр	1.Зонхилон гарч байгаа гэмт хэргийн шалтгаан нөхцлийг судлан тогтоосон байна. 2.Багийн иргэдийн нийтийн хурал, байгууллага хамт олны хурлаар хэлэлцсэн байна.

Хөтөлбөр 11.Цаг уурын ажиглалт хийх,

Хөтөлбөрийн хүрээнд: Цаг уурын ажиглалт явуулах, мэдээ өгөх, дамжуулах зэрэг ажил үйлчилгээ хамаарна.

№	Ажил үйлчилгээ	Тоо хэмжээ	Цаг хугацаа	Чанар үр дүн	Өртөг
1.	Цаг уурын ажиглалт явуулах.	365	Өдөр бүр	1.Ажиглалтыг тогтоосон цагт хийж батлагдсан маягаар тэмдэглэгээ хөтөлсөн байна. 2.Мэдээллийг үнэн зөв цуглуулж боловсруулалт хийсэн байна. 3.Бэлчээрийн ургац, цасны зузаан, хур тунадасны хэмжээ, салхины хүч, хүйтэн, халууны туйл зэргийг он сар, өдрөөр нарийн тэмдэглэсэн байна.	
2.	Цаг уурын мэдээ дамжуулах, урьдчилан сэргийлэх мэдээгээр сумын удирдлагыг хангах.	12	Сар бүр	1.Ажиглалтын мэдээг хугацаанд нь бүрэн өгсөн байна. 2.Урьдчилсан мэдээг сар бүр удирдлага иргэдэд сурталчилсан байна. 3.Аюулгүй үзэгдлийн мэдээг цаг алдалгүй мэдээлсэн байна.	

Хөтөлбөр 12.Статистикийн мэдээ мэдээллээр хангах

Хөтөлбөрийн хүрээнд: Мэдээлэл цуглуулах, боловсруулах, мэдээлэлээр үйлчлэх, хүргүүлэх, мал, хүн амын тооллого явуулах зэрэг ажил үйлчилгээг хамаарна.

№	Ажил үйлчилгээ	Тоо хэмжээ	Цаг хугацаа	Чанар үр дүн	Өртөг
1.	Статистикийн мэдээллээр хангах.	Мэдээл Лийн Тоогоор	Графикт хугацаанд	1.Мэдээний тоо баримт алдаа мадаггүй үнэн зөв байна. 2.Үзүүлэлтийг тооцхдоо нийтээр	

				<p>хүлээн зөвшөөрсөн аргачлалыг ашигласан байна.</p> <p>3.Мэдээний хамралтын хүрээ нь шаардлагын түвшинд байна.</p> <p>4.Үзүүлэлт бүр нь сумын хөгжил хөдөлгөөнийг харуулах чадвартай байна.</p> <p>5.Хэрэглэгчийн хэрэгцээ шаардлагыг бүрэн хангаж ашиглахад хялбар байна.</p>	
2.	Бусад мэдээллээр хангах	Мэдээний тоогоор	Заасан хугацаанд	<p>1.Цаг үеэ олсон байна.</p> <p>2.Ажлын шаардлагад нийцсэн байна.</p>	
3.	Тооллого явуулж дүн мэдээг нэгтгэн гаргах.	Тооллогын тоогоор	Заасан хугацаанд	<p>1.Мал сүргийн жилийн эцсийн тоог үнэн зөв хийж дүнг гаргасан байна.</p> <p>2.Хүн амын тоог үнэн зөв хийж дүнг гаргасан байна.</p> <p>3.Нийгэм эдийн засгийн болон Байгаль орчны бусад үзүүлэлтийн тооллогыг хэрэглэгчдийн заасан хугацаанд зохих үзүүлэлтээр нь тухай бүрт нь чанартай явуулж дүнг гаргасан байна.</p>	

ТӨЛӨВЛӨГӨӨ БОЛОВСРУУЛСАН:
 ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
 ДАРГА ДАЛТАНХУЯГ

